



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/75


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалт, Засгийн газрын 1999 оны 213 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 2021 оны 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэргийн мэргэжлийн зэрэг олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг мөрдөж ажиллахыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга /хурандаа Д.Ганхуяг/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, Төрлийн цэргийн командлагч /дарга/, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/ нарт үүрэг болгосугай.
3. Мэргэжлийн зэрэг олгох цэргийн мэргэжлийн жагсаалт, мэргэжлийн зэргийн үндсэн шалгуур үзүүлэлт болон мэргэжлийн зэргийн шалгалт явуулах зааврыг баталж, мөрдүүлэхийг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/-т даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2012 оны А/150 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Төрийн захиргааны удирдлагын газар /хурандаа Ч.Гандирваа/-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100189

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
04 дугаар сарын 04 ны өдрийн
А/75 дугаар тушаалын хавсралт

ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ алба хаагчид цэргийн мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Цэргийн мэргэжлийн зэрэг /цаашид “мэргэжлийн зэрэг” гэх/ гэж цэргийн алба хаагчийн эзэмшсэн цэргийн мэргэжлийн мэдлэг, дадал, ур чадварын түвшинг тогтоосон тусгай шалгуур үзүүлэлтийг хэлнэ.

1.3. Мэргэжлийн зэрэг нь III, II, I гэсэн шатлалтай байна.

1.4. Мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох үйл ажиллагааны нэгдсэн удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб /цаашид “ЗХЖШ” гэх/ хэрэгжүүлнэ.

1.5. ЗХЖШ нь цэргийн мэргэжлийн зэрэг олгох мэргэжлийн жагсаалт, мэргэжлийн зэргийн үндсэн шалгуур үзүүлэлт болон зэргийн шалгалт явуулах зааврыг тогтоож, мөрдүүлнэ.

1.6. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Төрлийн цэргийн командлагч /дарга/ нар мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох эрхийг энэхүү журамд заасны дагуу эдэлнэ.

1.7. Мэргэжлийн зэргийг офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч бүр эзэмших бөгөөд эзэмшсэн зэргээ 4 жил буюу 48 сарын дотор бататгах үүрэг хүлээнэ.

1.8. Цэргийн алба хаагч нь хэд хэдэн мэргэжлээр зэрэг эзэмшиж болно. Энэ тохиолдолд аль өндөр шатлалын зэргийн нэмэгдэл, урамшууллыг олгоно.

1.9. Мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална.

1.10. Цэргийн нисгэгч, нисэхийн инженер, техникийн бүрэлдэхүүн болон Тусгай хүчний цэргийн алба хаагчдын тусгай мэргэжлийн зэрэг олгох харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

Хоёр. Мэргэжлийн зэргийн комиссын ажлын зохион байгуулалт

2.1. ЗХЖШ-т цэргийн мэргэжлийн зэргийн төв комиссыг, Батлан хамгаалах яам, Төрлийн цэргийн командлал /удирдах газар/ болон Цэргийн нэгтгэл, анги, байгууллагад цэргийн мэргэжлийн зэргийн салбар комиссыг мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах үүрэгтэйгээр томилон ажиллуулна.

2.2. Цэргийн мэргэжлийн зэргийн төв болон салбар комисс нь мэргэжлийн зэргийн шалгалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж явуулна.

2.3. Цэргийн сургууль, дамжаа төгссөнөөс хойш 2 ба түүнээс дээш жил алба хаасан офицер, ахлагч, цэргийн гэрээт албанд элсэж 1 ба түүнээс дээш жил алба хаасан цэргийн гэрээт алба хаагч нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд мэргэжлийн зэргийн шалгалт /цаашид “зэргийн шалгалт” гэх/-д орох эрхтэй:

2.3.1.сүүлийн 2 удаагийн сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтаар “Сайн” түүнээс дээш дүнтэй суралцсан;

2.3.2.төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин нь сүүлийн 2 жилд “Хангалттай” түүнээс дээш үнэлэгдсэн;

2.3.3.хариуцсан цэргийн нэгтгэл, анги, байгууллага, салбар, алба, тасаг, нэгж нь сүүлийн 2 жил ажлын хариуцлага алдаагүй, алба хаагчид нь захиргааны болон сахилгын ноцтой зөрчил дутагдал гаргаагүй;

2.3.4.цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартыг хангасан.

2.4. Цэргийн мэргэжлийн зэргийн комисс нь энэ журмын 2.3.1-2.3.4-т заасан шаардлагыг хангаагүй цэргийн алба хаагчийг зэргийн шалгалтад хамруулахгүй.

2.5. Зэвсэгт хүчний цэрэгжлийн спортын төрлүүдээр явагдсан уралдаан, тэмцээнд оролцож өндөр амжилт үзүүлсэн алба хаагчийн цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартын шалгуур үзүүлэлтийг хангасанд тооцож болно.

2.6. Зэргийн шалгалтад орохыг хүссэн цэргийн алба хаагч нь хүсэлтээ шууд захирах даргаар уламжлуулан цэргийн мэргэжлийн зэргийн төв болон салбар комисст бичгээр гаргана.

2.7. Зэргийн шалгалтад орохыг хүссэн цэргийн алба хаагчийн бүрдүүлэх баримт бичиг, ирүүлэх хугацааг мэргэжлийн зэргийн төв болон салбар комисс тогтооно.

Гурав. Мэргэжлийн зэргийн төв болон салбар комиссын бүрэлдэхүүн,
тэдгээрийн эрх, үүрэг

3.1. ЗХЖШ-ын даргын шийдвэрээр Цэргийн мэргэжлийн зэргийн төв комисс /цаашид “төв комисс” гэх/-ыг томилох, чөлөөлөх бөгөөд комисс нь дарга, нарийн бичиг, гишүүд гэсэн 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.2. Төв комисс нь цэргийн мэргэжлийн III, II, I зэргийн шалгалтыг явуулна.

3.3. Төв комисс нь дараах эрх, үүрэгтэй:

3.3.1.энэ журмын 1.5-д заасныг баримтлан мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох ажлыг удирдан, зохион байгуулах;

3.3.2.мэргэжлийн зэргийн шалгалт явуулах арга хэлбэр, байр, хугацааг тогтоох;

3.3.3.шалгалтын асуулт, дасгал, нормативын хувилбарыг боловсруулж, төв комиссын даргаар хянуулж батлуулах;

3.3.4.мэргэжлийн зэрэг олгох салбар комиссын үйл ажиллагааг удирдах, салбар комиссын мэргэжлийн зэрэг олгуулах санал, баримт бичгийг хянаж дүгнэлт гаргах;

3.3.5.мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох саналыг боловсруулж, ЗХЖШ-ын даргад уламжлан шийдвэрлүүлэх;

3.3.6.мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгохтой холбоотой маргааныг хянаж, шийдвэрлэх;

3.3.7.хяналтын шалгалт явуулах;

3.3.8.цэргийн алба хаагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.3.9.Зэвсэгт хүчний хэмжээнд мэргэжлийн зэрэгтний тооцоо, судалгааг хөтлөх, мэргэжлийн зэрэгтний тоо, чанарыг нэмэгдүүлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлж санал, дүгнэлт боловсруулж хэрэгжүүлэх.

3.4. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Төрлийн цэргийн командлагч /дарга/-ийн шийдвэрээр цэргийн мэргэжлийн зэргийн салбар комисс /цаашид “салбар комисс” гэх/-ыг томилох, чөлөөлөх бөгөөд комисс нь дарга, нарийн бичиг, гишүүд гэсэн 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.5. Салбар комисс нь цэргийн мэргэжлийн III, II зэргийн шалгалтыг явуулна.

3.6. Салбар комисс нь дараах эрх, үүрэгтэй:

3.6.1.мэргэжлийн зэргийн шалгалтад орох, бататгах, хүчингүй болгох цэргийн алба хаагчийн материалыг хянаж, дүгнэлт гаргах;

3.6.2.мэргэжлийн зэргийн шалгалтын асуулт, дасгал, нормативын хувилбарыг боловсруулж, салбар комиссын даргаар хянуулж батлуулах;

3.6.3.мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцсэн цэргийн алба хаагчид мэргэжлийн III зэрэг олгуулах саналыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрлийн цэргийн командлагч /дарга/-д, цэргийн мэргэжлийн II зэрэг олгуулах тухай санал, шалгалтын материалыг төв комисст хүргүүлж шийдвэрлүүлэх;

3.6.4.мэргэжлийн I зэргийн шалгалтад орох, бататгах, хүчингүй болгох цэргийн алба хаагчийн материалыг төв комисст хүргүүлэх;

3.6.5.салбар комиссын үйл ажиллагааны тайлан, БХЯ, харьяа байгууллага, төрлийн цэргийн командлалын мэргэжлийн зэрэгтний судалгаа тооцоог хөтлөх, жил бүр тайлагнах;

3.6.6.мэргэжлийн зэрэг эзэмшүүлэхтэй холбогдсон асуудлаар цэргийн алба хаагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

3.7. Цэргийн нэгтгэл, анги, байгууллагад салбар комиссыг захирагч /дарга/-ийн шийдвэрээр томилох, чөлөөлөх бөгөөд комисс нь дарга, нарийн бичиг, гишүүд гэсэн 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.8. Салбар комисс нь цэргийн мэргэжлийн III зэргийн шалгалтыг явуулна.

3.9. Салбар комисс нь дараах эрх, үүрэгтэй:

3.9.1.мэргэжлийн зэргийн шалгалтад орох, бататгах, хүчингүй болгох цэргийн алба хаагчийн материалыг хянаж, дүгнэлт гаргах;

3.9.2.шалгалтын асуулт, дасгал, нормативын хувилбарыг боловсруулж, салбар комиссын даргаар хянуулж батлуулах;

3.9.3.мэргэжлийн III зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох саналыг төв болон харьяа командлал /удирдах газар/-ын салбар комисст тавьж, шийдвэрлүүлэх;

3.9.4.мэргэжлийн II, I зэргийн шалгалтад орох, бататгах, хүчингүй болгох цэргийн алба хаагчийн материалыг бэлтгэж төв комисс болон Батлан хамгаалах яам, Төрлийн цэргийн командлал /удирдах газар/-ын салбар комисст хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3.9.5.салбар комиссын үйл ажиллагааны тайлан, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын мэргэжлийн зэрэгтний судалгаа тооцоог хөтлөх, жил бүр тайлагнах;

3.9.6.мэргэжлийн зэрэг эзэмшүүлэхтэй холбогдсон асуудлаар цэргийн алба хаагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Мэргэжлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох

4.1. Цэргийн мэргэжлийн зэргийн төв комиссын саналыг үндэслэн ЗХЖШ-ын дарга цэргийн мэргэжлийн III, II, I зэргийг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Төрлийн цэргийн командлагч /дарга/ нь Цэргийн мэргэжлийн зэргийн салбар комиссын саналыг үндэслэн цэргийн мэргэжлийн III зэргийг тус тус олгоно.

4.2 Цэргийн алба хаагчид мэргэжлийн зэргийг шат дараалан олгоно.

4.3. Мэргэжлийн зэргийг дараах тохиолдолд олгоно:

4.3.1.мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийг хангаж, зэргийн шалгалтад тэнцсэн.

4.4. Дараах тохиолдолд мэргэжлийн зэргээ бататгасанд тооцно:

4.4.1.эзэмшиж буй мэргэжлийн зэргийнхээ шалгуур үзүүлэлтийг хангаж, тухайн цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцсэн;

4.4.2.мэргэжлийн зэрэг ахиулах шалгалтад тэнцээгүй боловч өмнөх мэргэжлийн зэргийнхээ шалгуур үзүүлэлтийг хангасан.

4.5.Мэргэжлийн зэргийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

4.5.1.мэргэжлийн зэрэг эзэмшсэн цэргийн алба хаагч нь энэхүү журмын 1.7-д заасан хугацаанд мэргэжлийн зэргээ бататгаагүй;

4.5.2.мэргэжлийн зэрэг эзэмших хугацаа дуусгавар болсон.

4.6. Мэргэжлийн зэрэг нь хүчингүй болсон цэргийн алба хаагч дахин мэргэжлийн зэргийн шалгалтад орох хүсэлтээ өөрийн харьяалах комисст гаргана. Энэ тохиолдолд сүүлийн эзэмшиж байсан цэргийн мэргэжлийн зэргээс 1 шатлал доогуур, хэрэв III зэрэгтэй байсан бол дахин эзэмшихээр III зэргийн шалгалтад тус тус орно.

Тав. Цэргийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл, баталгаажуулалт

5.1. Цэргийн мэргэжлийн зэрэг эзэмшсэн цэргийн алба хаагчид Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газраас тогтоосон цэргийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоно.

5.2. БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал /удирдах газар/-аас тухайн эзэмшсэн мэргэжлийн зэргийн энгэрийн тэмдэг /албаны болон хээрийн хувцасны/-ийг нэг удаа олгоно. Цэргийн алба хаагч мэргэжлийн зэргийн энгэрийн тэмдгээ хаяж, үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн харьяалах комисст хүсэлтээ гаргаж, хувийн зардлаар нөхөн авч болно.

5.3. Цэргийн алба хаагчийг цэргийн мэргэжлийн зэрэг эзэмшсэн тухай тэмдэглэлийг “Цэргийн алба хаагчийн сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний дэвтэр”-т хөтөлж, цэргийн мэргэжлийн зэргийн комиссын дарга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

---oOo---